

НҮҮДЭЛЧИД, МАЛЧИД, ИРГЭНШИЛ

М. Ууганбаяр¹

Б.Батчулуун “Соёл иргэншил ба нүүдэл” хэмээх өгүүлэлдээ нүүдэлчид ба иргэншлийн асуудлыг авч үзжээ. Тэрбээр нүүдэл бол соёл иргэншлийн өмнөх шат гэж дэлхийн түүхийн баримт болон түүнийг нэгтгэн дүгнэсэн социологи философи нийгмийн ухааны ажлууд өгүүлж байна. Дэлхийн судлаачдын хувьд хэдийнээ нэг мөр болсон соёл иргэншлийн тухай эл сэдэв манай хувьд бас л будлиантай хэвээр байна.” хэмээгээд соёл иргэншил гэж юу болох хийгээд яагаад нүүдлийн гэсэн үгтэй хослуулан хэрэглэхдээ дурамжхан байгаагаа тайлбарлажээ.

Б.Батчулуун “Хүйн үеийн бүдүүлгээс бүдүүлэг нь аргагүй ир гаргах төлий болсон юм уу аль эсвэл тодорхой хэлбэртэй болгосон чулууг мустье ашельегийн соёл гэдэг байгаль дээр ийм чулуу угаасаа байдаггүй, түүнийг хүн бүдүүн бааргаар ч гэсэн хувирган өөрчилсөн болохоор нь ингэж нэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл nature зүйл бус culture зүйл боллоо гэсэн үг Яг үүнтэй адилаар байгалийн аяар биш хүн тордож боловсруулж өөрийнхөө хүчин зүйлийг оруулан байж ургууллаг болохоор тариаг соёл хэмээн нэрлэж болно. ... И Б Тэйлорийн тодорхойлсоноор соёл буюу соёл иргэншил гэдэг нь мэдлэг, итгэл, урлаг, ёс суртахуун, хууль ёс, дадал заншил болон хүмүүсийн эзэмшсэн бусад чадвар юм” гээд “...хүн үүсэхэд хэл яриа, аж үйлдвэр үүсэхэд гал гэх мэт үзэгдлүүд үндэс нь болсон гэж ярьдагчлан соёл иргэншил үүсэхэд газар боловсруулалт үндэс нь болжээ. Соёл иргэншлийн анхны төвүүд гэж дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн Хятад, Энэтхэг, Ром, Египетийн соёл иргэншлийн үзэгдлүүд бүгд л газар тариалантай холбоотой байлаа. Эрт дээр үеийн хүмүүс хол тэжээлээ тогтмол олж чаддаг болсон тэр үе нь соёл иргэншлийн үндэс тавигдсан үе байлаа. Хоол хүнс тэжээлтэй байхын тулд түүнийг эрэн хайж явах юм уу хэрэн хэсүүчлэх шаардлагагүй болсон тэр байдал газар тариалантай л холбоотойгоор бий болжээ. Газар тариалан гэдэг бол ямар ч байсан тогтмол олдох хүнс тэжээл гэсэн үг. Энэ утгаараа газар тариалан суурьшлыг бий болгосон. Суурьшил гэдэг бол хөгжил. Хөгжил гэдэг бол соёл иргэншил. Тийм ч учраас civilization соёл иргэншил хэмээх үгийн үндэс нь civic- хот гэсэн латин үг байдаг. Үүгнээс уламжлаад Аристотель хотын хүнийг civilian-иргэн гэж нэрлэж байв. Тэгэхээр иргэн гэдэг бол хотожсон иргэн хүн юм. Аристотель иргэн гэдэг бол суурьшиж нийгэмшсэн хүн гэдэг санаагаа бүр тодотгож хүн бол зоон politician гэж тодорхойлсон. Энэ үгийг үгчлэн орчуулбал хүн бол улс төрийн амьтан гэвэл зохистой авч үндсэн санаа нь хүн бол polis хотод амьдрагч гэсэн утгатай байдаг. Тэгэхээр хүн хэлтэй, гартай, бодож сэтгэгдгээрээ амьтнаас ялгаатай гэхээсээ илүү их хотжиж иргэншиж нийгэмшсэнээрээ амьтнаас ялгаатай гэж хэлбэл илүү зохистой юм.

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

Хотод л худалдаа, үйлдвэр, урлаг, шинжлэх ухаан, улс төр гээд соёл иргэншлийн үндсэн үзэгдлүүд үүсдэг. Эндээс дүгнэхэд хүн байгалийн зүйлийг бэлэн аваад зогсохгүй өгөөгүй зүйлийг нь хүртэл бий болгож эхэлсэн тэр үеэс соёл иргэншил эхэлжээ. Энэ үеэс байгалийн хүн /Natural Man/байхаа больжээ. Тэгэхээр соёл иргэншил үүсэхэд газар тариалан маш том төдийгүй шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Ийм ч учраас зарим номон дээр зэрлэг хүн гэдгийг тариа тарьж мэддэггүй гэсэн утгаар ярьсан байдагХүнс тэжээл идэх юмтай байхын тулд байгалийн эрхшээлээр хэрэн хэсүүчлэх явдал бол хүний нийгмийн эртний бүдүүлэг хэв маяг юм. Түүн цуглуулах агнах бэлчээр дагах явдлууд нь энэ хэв маягт багтана. Нүүдлийн үе бол нийгмийн нэлээд доод шат... нүүдэлчид гэдэг бол амьдрахын тулд нэг газраас нөгөө газар луу хөдөлгөөн хийж байдаг хүмүүс юм. Үгийн үндэс болсон *nomad* гэсэн грек үг нь бэлчээр олохын тулд хэрэн хэсүүчлэгч гэсэн утгатай ажээ. Ихэнх нүүдэлчид тодорхой цаг хугацаанд тодорхой газар нутгийг сэлгэн амьдардаг. Нүүдэлчдийн нүүдэллэн явж буй шалтгаан нь түүн цуглуулах ан агнуур хөөх малын бэлчээр дагах гэх мэтээр байгалийн ая занг харсан шинжтэй байдаг. Ном зохиолд эдгээр хүмүүсийг ихэвчлэн байгалийн хүн гэж тодорхойлсон байдаг. Эндээс логик нөхөн гүйцээлт хийх юм бол байгалийн хүн гэсэн ойлголтын эсрэг ойлголт болох соёлжсон хүн-cultural man гэсэн ойлголт байх нь мэдээж.

Клайн Данелийн үзэж буйгаар тухайн үндэстэн “оршин ахуйдаа хэрэгтэй байгаа байгалийн юмсыг хэр зэрэг үл тоомсорлож байгаагаар соёлжсон байдал нь тодорхойлогддог” Өөрөөр хэлбэл тухайн үндэстэн соёлжиж иргэншсэн байх юм бол байгалийн эрхшээлийг дагаж бэмбэгнээд байхгүй өөртөө хэрэгтэй зүйл орчноо өөрөө бүтээн бий болгодог гэсэн утгатай байгаа юм. Монголчуудын бэлчээрийн мал аж ахуй дээр суурилсан нүүдэл нь түүн цуглуулах юм уу агнуурын ая харсан нүүдлээс эрс өөр хөгжиж боловсронгуй болсон хэв маяг болох нь ойлгомжтой гэвч нэгэнт нүүдэл л юм болсон хойно түүний хоцрогдмол шинжүүд байсаар байна. Манайд хөдөөдөө нүүдлийн мал аж ахуй нь үндсэндээ хэдэн зуу хэдэн мянган жилийн тэртээх байдлаараа оршиж байна. Нүүдэлчдийн соёл иргэншлийн онолын сэтгэлгээ гэдэг бол байдаггүй зүйл” гэхчлэн бичсэн байна. /Батчулуун 2000 40-47/

Бид бүхний дээр иш татаж үзүүлсэнчлэн, Б Батчулуун малчдыг нүүдэлчид гэж үзсэн, нүүдэлчид хэмээн дүгнэснээсээ улбаалаад бүдүүлэг юм уу байгалийн хүмүүс гэж үзсэн иргэншил суурьшил хотжилт нийгэмшлийг зөвхөн газар тариалантай холбосон зэрэг нь эргэлзээтэй юм.

Антропологичид дасан зохицох чадвар /adaptive strategies/ буюу ижил төслөг эдийн засгийн нөхцөл шалтгаан адил нийгэм соёлын үр дүнтэй байлаг гэсэн үзлээр түүгчид, цэцэрлэгчид, тариачид, малчид, аж үйлдвэр хэмээн таван үе шат болгон үзэхдээ хүнс тэжээл үйлдвэрлэл бий болохоос өмнөх цор ганц дасан зохицох чадвар байсан түүж цуглуулагчид, аж үйлдвэрийн бус нийгэм буюу хүнс тэжээлийн үйлдвэрлэлд суурилсан өсгөн үржүүлэхүйн /cultivation/ хэв маягаа цэцэрлэгчин, тариачин, малчин хэмээн гурав хувааж үзсэн байдаг /Cohen 1974: 45-68; Kottak 2005 :107 135, 2008 :151-177 /

Нөгөөтэйгүүр нүүдэл жинхэнэ утгаараа зөвхөн хоол хүнсний анхдагч хэрэгцээгээ хангахын тул хэрэн явдаг эдийн засгийн хувьд байгалиас бүрэн хамаармал байгалаг хэрэглээтэй суурьшилгүй анчид түүгчдийн дасан зохицох чадварт л хамаатай юм Түүгчил малчид нь дасан зохицохуйн хоёр өөр хэв маягт хамаарч буйгаас үзэхэд

малчид нүүдэлчид биш улмаар бүдүүлгүүд юм уу байгалийн хүмүүс биш болох нь тодорхой байна

Б. Батчулууны ярьсан шигээр газар тариалан ганцаараа иргэншлийг төлөөлөхгүй гэдгийг малчдыг өсгөн үржүүлэхүйн /cultivation/ нэг хэсэг хэмээн антропологичид үздэгээс харагдаж байна. Антропологичид малчдыг дотор нь нүүгчин /pastoral nomads/ хагас нүүгчин /transhumance/ хэмээн ангилсан байдгийг мэдээж бодож үзэх ёстой хэдий ч бидний дээр өгүүлсэн ялгаанаас болоод малчдыг нүүдэл гэх ойлголттой шууд холбох боломжгүй юм.

Тэгээд ч монголчуудын мал аж ахуйг нүүдэл хэмээх онолоор авч үзсэн эрдэмтэд ч мал аж ахуйг дотор нь нүүдлийн, хагас нүүдлийн, хагас суурьшлийн, сууршлийн аж ахуй гэж хуваасан зүйл байдаг нь дээр үзлийг далдуур дэмжих баримт гэлтэй. Ер нь байнгын гэр сууцгүйгээр ямар нэг хэмжээгээр байнгын өвөлжөө бүхий түүхийн туршид бүрэлдсэн уламжлалт маршрутаар хязгаарлагдмал давтамжтайгаар нүүдэллэх мал аж ахуйн нүүдлийн хэлбэр монгол нутагт зонхилж байжээ /С. И Вайнштейн 1972 71-73 /.

Малчдыг нүүдэлчид биш цаашлаад бүдүүлэг баларлигууд биш гэж бидний үзэж байгаатай алил санаа оноог түрэг судлаачид ч гарган тавьж байгаа юм. Түрэгүүдийг угтаа нүүдэлчид болох тухай санал бодол шинжлэх ухааны ертөнцөд түгээмэл бөгөөд лалын нэрт түүхч Ибн Халдун хүн төрөлхтнийг нүүдлийн ба иргэншсэн гэж хоёр нийгмийн хэв маягаар амьдардаг гэж хуваагаад алдарт долоон орчлын онолдоо Арабистаны цөлтэй адилтган үзсэн тал нутагт амьдрах түрэгүүдийг нүүдэлчид учир иргэншилд хүрэх нь түрэгүүдийн хувьд боломжгүй гэж бичсэн ба А. Тойнби нүүдэлчид ямар нэгэн шашин шүтлэггүй сүрэг бөгөөд замбараагүй хүмүүсийн бөөгнөрөл хөрш суурин газрын улс төрийн хоосон зайг ашиглаж уулгалан довтолдог эцэс төгсгөлгүй нүүдэл зогсонги байдалд орсон иргэншлүүд лүгээ адил мөхөх тавилантай түрэгүүд ч энэхүү түүхгүй хууль журамгүй нүүдэлчдийн нэг гэхчлэн бичсэн ажээ /Donuk 1987 495/.

Гэтэл И.Кафесоглү “Түрэг үнлэстэн түүхгүй бус урт хугацааны гялалзсан амжилтаараа баялаг түүхтэй гэдэг нь ил тол олон түмэн бөгөөд хууль журамгүй биш соёлын салшгүй хэсэг болох зохион байгуулалтын хүчээр олон тооны төр улс байгуулж байсан хууль эрхзүйн талаасаа шилэгдмэл үндэстэн бөлгөө. Үүнээс харвал түрэгүүдийг бүхэлдээ эсрэг утга агуулгатай нүүдэлчний нийгэм гэж тооцох боломжгүй юм” хэмээн суурин соёл ба шимэгч эдийн засгийн ялгааг гарган тайлбарласан байна /Donuk 1987 495/

И.Кафесоглү түрэгүүдийг нүүдэлчид бүдүүлгүүд гэдэг онолыг сөрөн зогсохдоо юуны өмнө түрэгчүүдийн морь адгуулдаг төмөр эзэмшиж байсан хэмээх хоёр гол шинжээрээ ямар ч байсан нүүдэлчид биш гэдэг нь илэрхий тул энэхүү өвөрмөц байдлыг нь харан талын соёл хэмээн нэрлэх санал дэвшүүлсэн билээ. Тэрбээр түрэгийн талын соёл хөгжин цэцэглэсэн газар нутаг бол Алтай уул болоод Саяны уулын баруун өмнө 500-1000 метр орчим тал газар буюу Андроновын соёлын орон зай өвс ногоо мал маллагаанд туйлын захиролтой хөндий хээр нутаг гэжээ.

И. Кафесоглү “...зөвхөн мал малладаг амьдралын хэв маягаас нь болоод эдийн засгийн үүднээс тал хээр газарт дэлгэрсэн мал маллагаанд тулгуурласан талын соёлыг нүүдэлчид гэж тодорхойлох нь буруу бөгөөд юуны өмнө түүхийн хөгжлийн төлөв нь сайн тодроогүй барууны эрдэмтэд өөрсдийнх нь соёлын ойлголтын гадна байх тул зохих ёсоор судалж чадаагүй нүүдэлчин ёсны сэтгэлгээ хууль шашин ёс суртахууны зан үйлдлэг одоогоор сайн мэдэгдэхгүй байна” гэснээс бодвол бид бүхэн малчдыг

нүүдэлчин буюу бүдүүлэг баларлаг мөн эсэхийг нарийвчлан судлахдаа бүдүүлэг соёл, бүдүүлэг сэтгэлгээ (primitive mentality), сүлд шүтлэг, онго шүтлэг, хамтын төсөөлөл, логикийн өмнөх сэтгэхүй, овог аймгийн соёл, хүнс тэжээлийн үйлдвэрлэл, бодитийн шинжлэх ухаан, онголог сэтгэхүй (savage mind), эцгийн эрхт ёс, эхийн эрхт ёс, бөө шүтлэг, суурьшил гэх мэт олон талаас харьцуулан үзэх хэрэгтэй болж байгаа юм /Bodley 2005 86 144 Kafesoglu 1995 202-203/

НОМ ЗҮЙ

1. Батчулуун Б Соёл иргэншил хийгээд нүүдэл Эрх чөлөө ба философи VII Улаанбаатар 2000
2. Вайнштейн С. И Историческая этнография тувинцев Проблемы кочевого хозяйства Москва 1972
3. Bodley John H Cultural Anthropology Tribes ,States, and the Global System McGraw –Hill 2005
4. Cohen Y Culture as Adaptation Man in adaptation : The Cultural Present Chigago:Aldine 1974
5. Donuk A Olumunun 3. Yil donumunde Kafesoglu ve Turk Devletinin Karakteri Turk Kulturu Sayi 292 yil XXV Agustos 1987
6. Kafesoglu I Turk Milli Kulturu Bogazici Yainlari Istanbul 1995
7. Kafesoglu I Turk Tarihi Kultur ve Teskilat Turk Dunyasi El Kitabi Ankara 1992
8. Kottak C P Anthropology The exploration of human diversity McGraw –Hill 2005
9. Kottak C P Cultural Anthropology McGraw –Hill 2008
10. Kottak C P Mirror for Humanity A Concise introduction to Cultural Anthropology McGraw –Hill 2005

SUMMARY

In this article the author discusses the relationship between Mongolian and Turkish pastoral nomads and their non-cultural naturalistic primitive lifestyle.

According to the author, Mongolian pastoralists are not merely nomads or primitives as several researchers think.